



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар Б/60

Чингис хот

Л.Наранбатыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2018 оны 264 дүгээр тогтоол "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай"-ын 9 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас Лхагвасүрэн овогтой Наранбатыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтнээр 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн туршилтын 2 сарын хугацаагаар томилсугай.

2. Л.Наранбатын цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 550744 /таван зуун тавин мянга долоон зуун дөчин дөрөв/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Л.Наранбатад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР